

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021.04.26

№ ХТ-21/01

Улаанбаатар хот

Огноо: 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр

Цаг: 10:00-11:50

Хурал болсон газар: *Цахимаар /live.mongolpost.mn/*

Хурлын дарга: *Д.Нарангэрэл /ТУЗ-ийн дарга/*

Хурлын нарын бичгийн дарга: *Д.Цэцгээ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/*

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 30

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 92,533,441

Хурлын ирц: 92.9%

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах,
2. Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах,
3. Компанийн 2019 оны ногдол ашиг тараасан тухай тайлан болон 2020 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах,
4. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсөв батлах,
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох,

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 10:00 цагт компанийн 306 хурлын танхимд цахим хэлбэрээр явагдлаа. Цахим хуралд хурлын дарга Д.Нарангэрэл, хараат бус гишүүн В.Ганзориг, Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар нар биечлэн оролцлоо. ТУЗ-ийн бусад гишүүд болон компанийн удирдлагын багийн гишүүд цахимаар хуралд оролцлоо.

Хурлын дарга Д.Нарангэрэл: Сайн байцгаана уу эрхэм хувьцаа эзэмшигчид ээ. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн энэ жилийн ээлжит хурал эхэлж байна. Цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан энэ жилийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр явуулж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг цахим хэлбэрээр байршуулсан. Та бүхэн материалтайгаа танилцсан байх.

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 2021 оны 04 сарын 19-ны өдрийн 10:00 цагаас 26-ний өдрийн 09:50 цаг хүртэл цахимаар бүртгэж, 2021 оны 04 сарын 26-ны өдрийн 10:00 цагт бүртгэлийн дүн буюу ирцийн дүнг нэгтгэн гаргаж, комиссын дарга Б.Нарантуяа нийт саналын эрхтэй хувьцааны 92.9 хувийн эзэмшигчид хуралд оролцож, хурлыг хүчин төгөлдөрт тооцсон тухай ирцийн мэдээлэл болон Тооллогын комиссын тогтоолыг хурлын дарга Д.Нарангэрэлд хүргүүлээ.

Хурлын дарга Д.Нарангэрэл ирцийн мэдээлэл болон хурлын дэгийг танилцуулснаар цахим хурал 10:00 цагт эхэллээ.

Хурлын дарга Д.Нарангэрэл: Цаг үеийн нөхцөл байдал, хатуу хөл хорио тогтоосон байдлаас шалтгаалан хэлэлцэх асуудалтай холбоотойгоор хурлын дэгд заасан хэлэлцэх асуудалтай холбоотойгоор танилцуулга хийх байсан гишүүд маань ирэх боломжгүй байгаа тул ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл миний бие болон хараат бус гишүүн В.Ганзориг нар тайлан танилцуулга хийхээр боллоо. Компанийн зүгээс Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан танилцуулна. Та бүхэн цахимаар зохион байгуулж байгаагаар холбоотойгоор санал, хүсэлтээ comment хэсэгт бичиж илгээгээрэй.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ – 1: Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

- “Монгол шуудан” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар цахим хурал оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэд мэндчилгээ дэвшүүлж, компанийн 2020 оны тайлан танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

- ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Аудитын хорооны дүгнэлтийг танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

- ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг компанийн 2019 оны ногдол ашиг тараасан тухай тайлан, 2020 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцууллаа.

Хурлын дарга Д.Нарангэрэл: Хувьцаа эзэмшигч Оюунболороос асуулт ирсэн байна. Нийт орлого өссөн боловч ашиг буурсан шалтгааныг тайлбарлаж өгнө үү гэсэн байна. Аудитын хорооны дүгнэлт танилцуулсантай холбоотойгоор үүнд тайлбар өгье. Цар тахалтай холбоотойгоор гадаадаас орох шуудан зогссон тул маш их хэмжээний орлого алдсан. Гэвч тусгай үүргийн нислэгийг ашиглаад гарах шуудангийн солилцоог өсгөж чадсан. Мөн дотооддоо хийж болох бүх боломжуудыг ашиглаж чадсанаар хамгийн бага хэмжээнд алдагдлыг бууруулж чадсан. Үндсэн үйл ажиллагаанаас алдагдал хүлээсэн. Гэвч түрээсийн орлого, хүүгийн орлого, валютын ханшийн зөрүү гээд энэ алдагдлыг бууруулах боломж гарсан. Компанийн удирдлагуудын хичээл зүтгэл, шууданчдийн нөр их хөдөлмөрийн үр дүнд 500 гаран сая төгрөгийн ашигтай гарч чадсан.

- ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны тайлан, дүгнэлтийг танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ – 2: ТУЗ-ийн 2021 оны зардлын төсөв батлах тухай;

- Хараат бус гишүүн В.Ганзориг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

Хувьцаа эзэмшигчдээс live.mongolpost.mn цахим хурлын чат-аар санал асуулга ирээгүй тул 3 дахь хэлэлцэх асуудлыг танилцууллаа.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ – 3: ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: ТУЗ-ийн гишүүдийг өнгөрсөн жил 2 жилийн хугацаатайгаар томилсон. Гэвч 2020 онд өөрсдийн хүсэлтээр 3 гишүүн чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлж, орлох гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл түр томилсон. Компанийн тухай хуулиар ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар томилсон бол нэг гишүүнд өөрчлөлт орсон

тохиолдолд бүрэн бүрэлдэхүүнээр нь дахин нэр дэвшүүлж томилдог байгаа. Иймд хуулийн заалтын дагуу ТУЗ-ийн бүх гишүүдийг дахин томилохоор танилцуулга оруулж ирж байна.

- ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулгыг хийв. /Танилцуулгыг хавсаргав/

Хурлын дарга Д.Нарангэрэл: Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууслаа. Та бүхнийг цахимаар саналаа ирүүлэхийг хүсье. Санал хураалтыг 11:40 цагт хаана.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр дээрх хэлэлцсэн асуудлуудын санал хураалтын ажиллагаанд орлоо.

- Хурал зохион байгуулах комиссын гишүүн Б.Сайнбаяр цахимаар санал өгөх зааврыг танилцууллаа.

Санал хураалтын дүнг нэгтгэж дууссан тул саналын дүнг нэгтгэж, Тооллогын комиссын дарга Д.Нарантуяа 11:45 цагт тогтоолыг хүргүүлж танилцууллаа. Мөн хурлын дэгийн дагуу “Монгол шуудан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолыг хурлын дарга Д.Нарангэрэл танилцууллаа.

Хурлын дарга Д.Нарангэрэл: Компаниас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, санхүү эдийн засгийн байдал, үүсээд байгаа нөхцөл байдал зэрэг 2020 оны үйл ажиллагаатай танилцаж хуралдаа идэвхитэй оролцсон хувьцаа эзэмшигч та бүхэндээ баярлалаа. Та бүхэн эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үүгээр өндөрлөж байна.

Энэ удаагийн хурал 11:50 цагт өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Д.НАРАНГЭРЭЛ

Д.ЦЭЦГЭЭ